Golomt Capital®

ТАВААРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Алт
Нүүрс
Төмрийн хүдэр
Зэс
Газрын тос

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.05.23

Golomt Capital®

АЛТНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 5-р сарын 23

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

Өнгөрөгч долоо хоногт алтны ханш 1.93%-иар өслөө. Ам.долларын ханш суларч байгаа нь хөрөнгө оруулагчдыг ханш нь хямд байгаа алтыг сонирхох гол шалтгаан болж байна.

Сент-Луисын Холбооны нөөцийн банкны ерөнхийлөгч Жеймс Буллард, АНУ-ын төв банкнаас инфляцийг хурдан хяналтандаа авахын тулд энэ онд бодлогын хүүг 3.5% хүртэл өсгөх ёстой гэсэн байр суурийг илэрхийлсэн байна.

Өндөр инфляц, бодлогын хүүний өсөлтөөс ирэх дарамт нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг сааруулах айдас байгаа тул хөрөнгө оруулагчид алтанд хөрөнгө оруулах сонирхолтой байна.

БНХАУ бол дэлхийн хамгийн том алт хэрэглэгч орон юм. Тус улс хөл хорионы дэглэмээ хэсэгчлэн цуцалж эхэлсэн тул эрэлт нэмэгдэж алтын ханш өснө хэмээн таамаглаж байна.

Дэлхийн хамгийн том алтаар баталгаажсан биржээр арилжаалагддаг сан болох SPDR Gold Trust нь өвөрсдийн нөөцөө 0.69%-иар нэмэгдүүлж 1063.43 тонн болгосон байна.

Мэдэгдэл: *Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*

Golomt Capital®

ГАЗРЫН ТОСНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 5-р сарын 23

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

- БНХАУ-аас ОХУ-ын нефтийг хямдралтай үнээр худалдаж авах бодолтой байгаагаа илт илэрхийлснээр нефтийн үнэ буурлаа.

ОХУ-ын хувьд ЕХ руу нийлүүлдэг байсан газрын тосоо газрын тосны хэрэглээгээр дэлхийд дээгүүрт жагсдаг Хятад, Энэтхэг рүү хямдралтай үнээр нийлүүлэх сонирхолтой байна.

Харин ЕХ нь Унгарыг Оросын нефтийн импортын хоригийг хүлээн зөвшөөрөхийг ятгаж чадахгүй байна.

- АНУ-ын тээвэрлэлтийн оргил улирал уламжлал ёсоор 5 сарын сүүлчээр Дурсамжийн өдрөөр эхэлж, 9 сарын Хөдөлмөрийн өдрөөр дуусдаг.

Энэ үед нефть боловсруулах үйлдвэрүүд АНУ-ын өндөржүүлсэн горимд ажилладаг.

Шинжээчдийн үзэж байгаагаар шатахууны үнийн өсөлт эрэлтийг бууруулж болзошгүй гэж эмээж байсан ч тоон мэдээлэл эрэлт өссөөр байгааг илтгэж байна.

Мөн даваа гарагт ам.долларын ханш суларсан нь газрын тосны үнэ өсөхөд нөлөөллөө.

Мэдэгдэл: *Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*